ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Дорноговь аймгийн Номын сан 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2019/131/СТА-ТШЗ


Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас:7052-2734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Лүндэгмаа
Утас: 7052-3020 Цахим хаяг: ..............................
Аудитор: М.Бямбадорж
Утас: 99031981 Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь
2019 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1 Аудитын гэрчилгээ 3
2 Аудитын тайлан 5
2.1 Оршил ........ 5
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ........ 5
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ........ 6
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ........ 6
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ........ 7
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ........ 7
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ........ 8
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ........ 8
2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал…..9
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ........ 9
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ........ 9
2.11. Шилэн дансны мэдээлэл ........ 10
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ........ 10
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ........ 10
3 Менежментийн захидал 11
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

# 1 Аудитын гэрчилгээ

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019.03.04 № 1-6/261

танай ______ -ны № ______ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
НОМЫН САНГИЙН
ЗАХИРАЛ
А.БАЙГАЛМАА ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Дорноговь аймгийн Номын сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймгийн Номын сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Номын сангийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 54.3, 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА

# 2 Аудитын тайлан

## 2.1. Оршил

Дорноговь аймгийн номын сан 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг  Захирал А.Байгалмаа-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн номын сан 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн номын сан 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 02 дугаар сарын 22-наас 27–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын гэрээт “Мөнгө Нөөц Баялаг аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Аймгийн Төв номын сан 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн номын сан талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Аймгийн Төв номын сан нь Соёлын үнэт зүйл болох ном хэвлэлийг хадгалж, хамгаалах , ард иргэдэд ном соёлоор үйлчлэн тэдний оюуныг хөгжүүлэх, бүтээлч санаачилгыг өрнүүлэх, орчин үеийн техник технологи нэвтрүүлэх, тав тухтай тохилог орчин бүрдүүлэх ,номын сангийн стандартыг ханган ажиллахад оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Соёлын тухай хуулиар Дорноговь аймгийн номын сан үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийтийн номын сан
- Архив

Дорноговь аймгийн номын сан үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн номын сан удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Соёлын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байхгүй

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн номын сан санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулахгүй  гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Аймгийн Төв номын сан санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн номын сан дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт нөлөөгүй)гэж үзлээ.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн номын сан бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 0 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогын 2% хувиар сонгов.

Нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгийн дүн өндөр байгаа тул байгууллагын нийт орлогыг суурь үзүүлэлт болгон сонголоо.

Дорноговь аймгийн номын сан 2018 оны нийт орлого нь 185946,2 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 3718,9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг нийт орлогын суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь нийт орлогын 2 хувь буюу 3718,9 мянган төгрөгөөс хэтэрсэн алдааг материаллаг хэмжээтэй гэж үнэлэхтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

### 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 0 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 4 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Зөвлөмж өгсөн | 1 | 820.00 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 0 | 0.00 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 1 | 1,152.20 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| | Дүн | 2 | 1,972.20 | |

### 2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- Тайлант хугацааны гэрэл цахилгааны зардал, цахилгааны өглөг, цахилгааны нэхэмжлэлийг дахин тооцоолоход зөрүүгүй илэрхийлэгдсэн боловч авлага өглөгийн тодруулга тайлангаар уг зардлаас цахилгааны эд зүйл худалдан авахад 1152,2 мянган төгрөгийг зарцуулсан болох нь нотлогдсон бөгөөд уг үйлдэл нь Сангийн сайдын 2015 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн №07 тоот тушаал, Сангийн сайдын 2014 оны №55 тоот тушаалтай тус тус зөрчилдөж бүлэг хооронд шилжүүлэн гүйлгээ хийсэн байна.

### 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой хөдөлгөөн, түүний бүртгэл

Цалин хөлсний суутгал, олголт

### 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн номын сан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 8 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 153643.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 154002.6 мянган төгрөг буюу 99,8 хувьтай байгаа нь шалтгаалжээ.

### 2.11. Шилэн дансны мэдээлэл

Аймгийн Төв номын сан Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар өмнөх аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### 2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн номын сан 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн номын сан 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

# 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн номын сан нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

## Зардлын данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт**

Жилийн турш хуримтлал гэсэн ангиллаар 820.0 мянган төгрөгийн суутгал хийгдсэн, сар бүрийн эцэст цалинг 1 удаа бодон олгож буй зэрэг нь гарт олгох цалинг хууль бус суутгал хийн бууруулах, ажиллагсдын хуулиар олгосон эрхээ эдлэх боломжгүй болгож байна.

Энэ нь үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хөдөлмөрийн хуулийн 60.1, 63.1.1, 63.1.2 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

**Зөвлөмж**

Шүүхийн шийдвэр болон холбогдох бусад эрх зүйн актгүйгээр цалингаас суутгал хийхгүй байх, ажиллагсдын цалинг сард 2 удаа бодож олгох.

**Хариуцах ажилтан**

Дорноговь аймгийн Номын сангийн захирал А.Байгалмаа, нягтлан бодогч Г.Баярчимэг

**<u>Эрсдэл</u>**

1. Ажиллагсдын гарт олгох цалингаас хууль бусаар суутгал хийснээр тэдний гарт олгох цалин буурах

**<u>Төсвийн захирагчийн хариу</u>**

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой

**Илрүүлэлт**

Бид тус байгууллагын санхүүгийн тайланг 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 20 цагт хүлээн авсан бөгөөд энэ нь биднийг аудитын ажлыг төвлөсөн цаг хугацаандаа гүйцэтгэх боломжийг хязгаарах эрсдэл үүсгэсэн.

Энэ нь үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 8.9.1.төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх гэсэн заалтыг мөрдөн ажиллах

**Зөвлөмж**

Төсвийн шууд захирагч нягтлан бодох бүртгэл, хяналтын үйл ажиллагаанд тавих хяналтаа сайжруулах

**Хариуцах ажилтан**

Дорноговь аймгийн Номын сангийн захирал А.Байгалмаа, нягтлан бодогч Г.Баярчимэг

**Эрсдэл**

1. Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа доголдох, тайлан мэдээг цаг тухай бүрт нь гаргахгүйгээс мэдээлэл хэрэглэгч нарыг үнэн зөв мэдээллээр хангах боломжгүй болох.

**Төсвийн захирагчийн хариу**

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ**

**ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ЛҮНДЭГМАА Огноо:

**БЭЛТГЭСЭН:**

АУДИТОР М.БЯМБАДОРЖ Огноо:

## 4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 4.1 АУДИТАЛСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **10,574,698.87** | **11,927,519.02** |
| **33** | **АВЛАГА** | 1,666,333.00 | 00.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 360,000.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 1,306,333.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1,306,333.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 8,908,365.87 | 11,927,519.02 |
| **354** | **Хангамжийн материал** | 8,908,365.87 | 11,927,519.02 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,296,800.00 | 1,481,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,416,525.00 | 8,416,269.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 00.02 | 00.02 |
| 35450 | Барилгын засварын материал | 2,011,080.00 | 2,029,950.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 183,960.85 | 00.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **281,839,393.72** | **319,341,272.63** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 281,839,393.72 | 319,341,272.63 |
| **392** | **Биет хөрөнгө** | 281,151,893.58 | 313,997,272.63 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 303,181,496.00 | 180,028,300.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -146,430,733.42 | 00.00 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 21,400,000.00 | 21,400,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -18,724,999.87 | -21,400,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 29,412,844.05 | 36,594,944.05 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -23,918,749.18 | -20,473,575.78 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 33,709,903.60 | 36,025,748.60 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -15,040,983.28 | -18,322,127.12 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 249,950.00 | 249,950.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -6,386.32 | -10,552.12 |
| 39217 | Ном | 97,319,552.00 | 99,904,585.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 687,500.14 | 5,344,000.00 |
| 39301 | Програм хангамж | 5,900,000.00 | 5,900,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -5,212,499.86 | -5,900,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 00.00 | 5,344,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **292,414,092.59** | **331,268,791.65** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **720,000.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 720,000.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 720,000.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **291,694,092.59** | **331,268,791.65** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 291,694,092.59 | 331,268,791.65 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 200,539,363.60 | 205,883,363.60 |
| 51101 | Өмч: - төрийн | 200,539,363.60 | 205,883,363.60 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 91,154,728.99 | 97,054,865.59 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 91,154,728.99 | 91,154,728.99 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 5,900,136.60 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 00.00 | 28,330,562.46 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **292,414,092.59** | **331,268,791.65** |

**4.2 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **185,946,206.00** | **###########** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **40,430,096.00** | **22,544,100.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 40,430,096.00 | 22,544,100.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 40,430,096.00 | 7,499,100.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,045,800.00 | 910,900.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 39,384,296.00 | 6,588,200.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 15,045,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **10,114,110.00** | **3,000,000.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 135,402,000.00 | ########### |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 10,114,110.00 | 3,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,114,110.00 | 3,000,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **151,977,001.17** | **###########** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **151,977,001.17** | **###########** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 141,473,147.17 | ########### |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 87,174,887.00 | 92,342,479.00 |
| 210101 | Үндсэн цалин | 87,174,887.00 | 92,342,479.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 9,917,718.00 | 11,715,196.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,382,585.00 | 8,069,418.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 788,775.00 | 793,189.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 865,380.00 | 620,665.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 172,295.00 | 367,992.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,708,683.00 | 1,863,932.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 16,336,490.00 | 16,589,025.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 758,969.00 | 1,009,902.00 |
| 210302 | Түлш, халаалт | 15,209,789.00 | 15,114,243.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 367,732.00 | 464,880.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,395,368.00 | 6,126,374.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,805,300.00 | 1,504,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 429,200.00 | 273,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,345,248.00 | 3,689,929.50 |
| 210404 | Ном, хэвлэл | 671,620.00 | 366,940.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 144,000.00 | 144,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 147,405.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 695,370.00 | 157,915.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 695,370.00 | 157,915.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,016,580.00 | 5,769,290.85 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 52,140.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,016,580.00 | 5,717,150.85 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 194,700.00 | 190,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 194,700.00 | 190,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,149,950.00 | 1,860,330.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,736,700.00 | 1,425,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 117,300.00 | 117,300.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 141,100.00 | 141,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 136,050.00 | 105,500.00 |

## 4.3 АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **146,538,910.00** | ########### |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,022,800.00** | **15,955,900.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,022,800.00 | 15,955,900.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,022,800.00 | 910,900.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,022,800.00 | 910,900.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 15,045,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **145,516,110.00** | ########### |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 135,402,000.00 | ########### |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 10,114,110.00 | 3,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,114,110.00 | 3,000,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **139,351,360.00** | ########### |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **139,351,360.00** | ########### |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **128,811,506.00** | ########### |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 87,174,887.00 | 92,872,062.00 |
| 210101 | Үндсэн цалин | 87,174,887.00 | 92,872,062.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 9,521,718.00 | 11,545,613.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 5,986,586.00 | 7,773,372.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 788,774.00 | 829,189.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 865,380.00 | 674,054.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 172,296.00 | 333,552.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,708,682.00 | 1,935,446.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,699,323.00 | 16,434,892.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,815,469.00 | 2,162,102.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,109,654.00 | 13,179,274.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 774,200.00 | 1,093,516.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,426,968.00 | 6,762,599.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 917,900.00 | 1,247,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 429,200.00 | 273,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,691,248.00 | 3,648,489.50 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,244,620.00 | 850,380.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 144,000.00 | 144,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 599,130.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 381,300.00 | 387,094.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 381,300.00 | 387,094.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,412,660.00 | 6,689,640.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 1,039,340.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 339,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,412,660.00 | 5,310,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 194,700.00 | 190,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 194,700.00 | 190,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,999,950.00 | 1,860,330.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,586,700.00 | 1,425,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 117,300.00 | 117,300.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 141,100.00 | 141,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 136,050.00 | 105,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 18,800.00 | 43,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 28,430.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **10,539,854.00** | **362,759.50** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 10,360,800.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 6,760,800.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,600,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 179,054.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 179,054.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 362,759.50 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 362,759.50 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **7,187,550.00** | **16,900,010.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **7,187,550.00** | **16,900,010.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **7,187,550.00** | **16,900,010.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 7,187,550.00 | 16,900,010.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 7,187,550.00 | 16,900,010.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-7,187,550.00** | ########### |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.0 | 00.0 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.0 | 00.0 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.0 | 00.0 |

## 4.4 АУДИТЛАГДСАН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 200,539,363.60 | 41,476,186.42 | 17,673,599.32 | 259,689,149.34 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **200,539,363.60** | **41,476,186.42** | **17,673,599.32** | 259,689,149.34 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 33,969,204.83 | 33,969,204.83 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **00.00** | 00.00 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **200,539,363.60** | **00.00** | **91,154,728.99** | 291,694,092.59 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **200,539,363.60** | **00.00** | **91,154,728.99** | 291,694,092.59 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 28,330,562.46 | 00.00 | 28,330,562.46 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 5,344,000.00 | 00.00 | 5,900,136.60 | 11,244,136.60 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **205,883,363.60** | **28,330,562.46** | **97,054,865.59** | 331,268,791.65 |

## 4.5 АУДИТАЛСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 136,009,900.00 | 135,601,260.50 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 136,009,900.00 | 135,601,260.50 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 136,009,900.00 | 135,601,260.50 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 93,164,700.00 | 92,872,062.00 |
| 210101 | Үндсэн цалин | 93,164,700.00 | 92,872,062.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 11,647,700.00 | 11,545,613.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,205,200.00 | 7,773,372.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 688,500.00 | 829,189.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 860,600.00 | 674,054.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 172,100.00 | 333,552.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,721,300.00 | 1,935,446.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 16,436,200.00 | 16,434,892.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,245,500.00 | 2,162,102.00 |
| 210302 | Түлш, халаалт | 13,097,100.00 | 13,179,274.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,093,600.00 | 1,093,516.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,484,900.00 | 8,480,169.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 824,100.00 | 1,247,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 275,900.00 | 273,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,500,000.00 | 1,728,489.50 |
| 210404 | Ном, хэвлэл | 5,140,900.00 | 4,487,950.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 144,000.00 | 144,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 600,000.00 | 599,130.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 387,100.00 | 387,094.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 387,100.00 | 387,094.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,257,200.00 | 5,255,300.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 339,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,257,200.00 | 4,915,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 194,700.00 | 190,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 194,700.00 | 190,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 437,400.00 | 435,330.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 117,300.00 | 117,300.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 141,100.00 | 141,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 105,600.00 | 105,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 43,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 29,400.00 | 28,430.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 136,009,900.00 | 135,960,800.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 135,049,900.00 | 135,049,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 135,049,900.00 | 135,049,900.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 960,000.00 | 910,900.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 960,000.00 | 910,900.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 12.00 | 14.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 08.00 | 09.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 03.00 | 04.00 |